



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/668

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1.1 дэх заалтыг үндэслэн "Үйлдвэрлэгч-Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас олгосон буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Үйлдвэрлэгч -Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан дүн, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд зээл олгосугай

2. Зээл олгох аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах 273.0 сая төгрөг/ хоёр зуун далан гурван сая/ -ийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас олгосон буцалтгүй тусламжийн хөрөнгийг зарцуулах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, мөнгөн дүнг баталсан аймгийн Засаг даргын 2019 оны 10 дүгээр сарын 08-ны өдрийн А/620 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын санхүүжүүлэх арга хэмжээний жагсаалтын 8-д заасан " Үйлдвэрлэгч Ховд" хөтөлбөрт санхүүгийн дэмжлэг олгох зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга / Ш.Багдал /, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч / Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/668 Ch
02 03318

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар
сарын 15-ны өдрийн А/668 дугаар
захирамжийн хавсралт

“ҮЙЛДВЭРЛЭГЧ-ХОВД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
АЖ АХУЙН НЭГЖИД ОЛГОХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Хүссэн зээл	Олгох зээл
1.	“Буянт үйлийн шим” хоршоо	Ажлын хувцасны үйлдвэр байгуулах	60.000.000	20.000.000
2.	“Эко гутал” ХХК	Ажлын гутал үйлдвэрлэх	50.000.000	45.000.000
3.	Иргэн Б.Нурлан	Хүнсний ногоо, хадлан бэлтгэх	68.000.000	15.000.000
4.	Иргэн Т.Бямбатөмөр	“Баянбүрд мод үржүүлгийн газар байгуулах	10.000.000	10.000.000
5.	Иргэн Д.Баярмандал	“Ач Оюундалай” лаборатори, эмнэлгийн тоног төхөөрөмж шинэчлэх	10.000.000	10.000.000
6.	“Хүсэл тэмүүлэлийн дөл” ХХК	Сийлбэртэй модон эдлэл	50.000.000	20.000.000
7.	“Мянгат чаргат” хоршоо	Ингэний хоормогоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх	30.000.000	20.000.000
8.	Иргэн М.Баточир	Гоёлын гутал үйлдвэрлэх	54.000.000	20.000.000
9.	Иргэн Р.Цэцгээ	“Цэцэг салон”	20.000.000	15.000.000
10.	Иргэн Ц.Алтнаа	“Миний урлан”	8.000.000	8.000.000
11.	Иргэн А.Руслан	Авто цахилгаан засвар	15.000.000	15.000.000
12.	“Өв эс” ХХК	Хими цэвэрлэгээний үйл ажиллагааг өргөтгөх	50.000.000	20.000.000
13.	Иргэн Б.Баярхүү	Жуулчны баазын үйл ажиллагааг өргөтгөх	30.000.000	10.000.000
14.	“Дунд голын рашаан” ХХК	Хүүхдийн цэцэрлэг өргөтгөх	30.000.000	15.000.000
15.	“Цагаан шувуут тулга” ХХК	Банш, буузны цех өргөтгөх	20.000.000	10.000.000
16.	“Ховд скай” ХХК	Савласан тараг сүү үйлдвэрлэх	74.000.000	20.000.000
	Нийт дүн			273.000.000